



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар Б/04

Мөрөн сум

Б.Долгорнямааг түр орлон гүйцэтгэх
ажил албан тушаалд томилох тухай.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43.3.3, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтын 2.2 дах заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын Мал аж ахуй үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэл, Бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын орон тоог Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлөөс нөхөх боломжгүй байгаа тул Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Долгорнямаа)-г 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.(Б.Долгорнямаа)-д олгох цалинг түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар бодож сар бүр олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Засаг даргын Тамгын газрын Мал аж ахуй үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэл, бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгэхдээ албан тушаалын тодорхойлолт заасан чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцаж ажиллахыг (Б.Долгорнямаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ